



ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Ш. БОЛОРСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.20 № 0/01

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн тусгай хамгаалалтын газрын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Төрийн тусгай хамгаалалтын газраас 2012 оны 12 дугаар сарын 12-д хөдөлмөрийн аварга 17 ажилтанд 7,9 сая төгрөгийн шагнал олгохдоо тооцоололын алдаа гаргаж, нийгмийн даатгалын шимтгэлд 338485 төгрөгийг суутгаж аваагүй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...” гэж заасныг үндэслэн **АКТ ТОГТООХ НЬ:**

1. Нэр бүхий 17 хүнээр 338485 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлэн Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 900000601 дугаар дансанд 2013 оны 4 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлэх,
2. Тогтоосон актын төлбөрийг барагдуулах ажлыг тус газрын Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч А.Түвшин, нягтлан бодогч Б.Болормаа нарт хариуцуулав,
3. Актын биелэлтийг гаргаж, 2013 оны 4 дүгээр сарын 20-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

ТОГТООСОН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

 Л.ОДГЭРЭЛ

УХА0122

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ТТХГ-ЫН САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА,
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 А.ТҮВШИН

НЯГТЛАН БОДОГЧ

 Б.БОЛОРМАА

070005